**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/2/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2024.03.25

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Алтантуяа
Утас: 99442140 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор: Б.Наранцэцэг
Утас: 88093788 Цахим хаяг: Narantsetsegbat@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 6

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 15

**3.4.1 Мөнгөн хөрөнгө** ........ 17

**3.5.2 Авлага** ........ 17

**3.5.4 Бараа материал** ........ 17

**3.5.6 Үндсэн хөрөнгө** ........ 18

**3.5.7 Өр төлбөр** ........ 19

**3.5.10 Засгийн газрын хувь оролцоо** ........ 20

**3.5.11 Орлогын данс** ........ 20

**3.5.12 Зардлын данс** ........ 21

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 25

**4.1 Ерөнхий зүйл** ........ 25

**4.2 Материаллаг байдал** ........ 26

**4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 26

**4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 26

**4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 26

**4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 27

**4.7.1 Завсрын аудитын талаар** ........ 27

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 27

**5.1 Албан шаардлага** ........ **Error! Bookmark not defined.**

**5.2 Зөвлөмж** ........ 27

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХЖАРГАЛ ТАНАА

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.03.25 № 2/112

танай ____________-ны № ____________ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Жаргалант сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн нэгтгэсэн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

5020412

Тус сум нь 15 нэр төрлийн орлогоор 359,100.8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 601,242.1 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 167.4 хувьтай биелүүлж, орон нутгийн төсөвт 32,643.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Жаргалант сумын Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2023 оны хэрэгжилтийг 91.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Жаргалант сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Жаргалант сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ


5020411
procurement.bayankhongor@audit.gov.mn
64101 (976) 70442584



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **671,612.42** | **832,204.85** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **383,643.82** | **494,470.30** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **383,643.82** | **494,470.30** |
| **31210** | **Төгрөг** | **383,643.82** | **494,470.30** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 383,643.82 | 494,470.30 |
| **33** | **АВЛАГА** | **158,534.68** | **185,229.74** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 3,500.00 | 3,516.00 |
| **33500** | **Бусад авлага** | **5,320.56** | **0.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 5,320.56 | 0.00 |
| **33600** | **Зээлийн авлага** | **149,714.12** | **181,713.74** |
| **33610** | **Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага** | **149,714.12** | **181,713.74** |
| 33612 | Хувь хүмүүст олгосон зээл | 149,714.12 | 181,713.74 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **114,433.92** | **152,504.81** |
| **35400** | **Хангамжийн материал** | **83,045.44** | **106,318.55** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,720.58 | 2,865.58 |
| 35420 | Аж ахуйн материал | 19,981.94 | 46,115.67 |
| 35450 | Барилгын засварын материал | 390.80 | 390.80 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 60,952.12 | 56,946.50 |
| 35600 | Мал амьтад | 31,388.48 | 46,186.26 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | **15,000.00** | **0.00** |
| 36100 | Барааны нөөц | 15,000.00 | 0.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,319,318.79** | **1,364,780.01** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,319,318.79** | **1,364,780.01** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,216,506.79** | **1,261,968.01** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 808,498.61 | 899,994.02 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -164,501.18 | -196,223.67 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 226,610.80 | 199,800.80 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -147,780.80 | -137,613.47 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 272,597.86 | 312,266.66 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -165,515.72 | -196,272.46 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 124,365.52 | 109,438.87 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -49,699.75 | -45,555.23 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 194,620.00 | 214,620.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -94,357.25 | -106,888.25 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 451,746.13 | 495,557.93 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -240,077.42 | -287,157.19 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **102,812.00** | **102,812.00** |
| 39301 | Програм хангамж | 200.00 | 200.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -200.00 | -200.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 102,812.00 | 102,812.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,990,931.22** | **2,196,984.86** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **63.23** | **5,612.99** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **63.23** | **5,612.99** |
| **41300** | **Өглөг** | 63.23 | 5,612.99 |
| **41360** | **Бусад өглөг** | 63.23 | 5,500.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 63.23 | 5,500.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,990,867.99** | **2,191,371.87** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,990,867.99** | **2,191,371.87** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 547,324.88 | 547,324.88 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 547,324.88 | 547,324.88 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,351,270.82** | **1,554,218.59** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 5,808,478.52 | 1,343,414.71 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -4,457,207.69 | 210,803.88 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 92,272.28 | 89,828.40 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,990,931.22** | **2,196,984.86** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,243,420.80** | **2,902,134.43** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **434,836.52** | **585,400.01** |
| **110** | **Орлогын албан татвар** | **209,087.48** | **238,092.39** |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | **209,087.48** | **238,092.39** |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх | 153,123.22 | 186,314.88 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 18,683.10 | 10,279.64 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 35,405.56 | 40,389.95 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны орлого | 1,875.60 | 1,107.92 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | **57,696.51** | **68,986.14** |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 1,006.11 | 2,214.87 |
| 113002 | Бууны албан татвар | 8,040.00 | 7,620.00 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | 48,650.40 | 59,151.27 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | **168,052.54** | **278,321.48** |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | **11,714.36** | **13,265.84** |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 7,783.33 | 8,768.79 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 286.00 | 637.68 |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 3,645.03 | 3,859.37 |
| **1181** | **Газрын төлбөр** | **2,311.31** | **4,413.13** |
| 118101 | Газрын төлбөр | 2,311.31 | 4,413.13 |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | **154,026.86** | **260,642.51** |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 154,026.86 | 260,642.51 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **293,224.38** | **399,595.61** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **293,224.38** | **399,595.61** |
| 120003 | Торгуулийн орлого | 19,339.50 | 15,842.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **11,651.16** | **124,956.03** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,098.51 | 48,547.44 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,552.65 | 76,408.59 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 214,967.09 | 177,886.80 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 47,266.63 | 80,910.78 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,515,359.89** | **1,917,138.81** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **41,421.40** | **32,643.59** |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 41,421.40 | 32,643.59 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **24,919.09** | **2,795.25** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 24,919.09 | 2,795.25 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,449,019.40** | **1,881,699.97** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 695,511.80 | 939,489.37 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 555,685.10 | 679,299.80 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 197,822.50 | 262,910.80 |

| | | | |
|---|---|---|---|
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,022,122.17** | **2,688,974.25** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,022,122.17** | **2,688,974.25** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **923,893.05** | **1,391,975.83** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **280,414.62** | **422,339.90** |
| 210101 | Үндсэн цалин | 212,707.74 | 311,090.11 |
| 210102 | Нэмэгдэл | 40,899.22 | 94,464.53 |
| 210104 | Урамшуулал | 24,167.19 | 16,785.26 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,640.47 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **36,011.75** | **52,999.63** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,404.40 | 36,103.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,790.56 | 4,273.26 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,079.78 | 3,457.26 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 684.93 | 833.80 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,052.08 | 8,331.84 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **54,792.49** | **81,393.51** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,850.49 | 9,681.66 |
| 210302 | Түлш, халаалт | 49,942.00 | 71,711.86 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **95,883.72** | **81,663.32** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,628.21 | 11,987.47 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 46,613.83 | 49,863.55 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,115.60 | 3,589.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,790.90 | 838.30 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 643.00 | 385.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 33,592.19 | 0.00 |
| 210409 | Бараа материал шилжүүлсний зардал | 3,500.00 | 15,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,466.40** | **20,106.50** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 629.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,837.40 | 20,106.50 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **8,156.00** | **18,682.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,156.00 | 18,682.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **240,843.44** | **432,686.29** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 237,321.44 | 431,038.79 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 400.00 | 337.50 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 218.00 | 200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 240.00 | 110.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 564.00 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,300.00 | 1,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 300.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **204,324.63** | **282,104.68** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 70,246.77 | 108,461.17 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,648.80 | 3,495.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 128,429.05 | 170,148.51 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,098,229.12** | **1,296,998.42** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **31,535.20** | **20,253.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 17,966.20 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,569.00 | 20,253.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,066,693.92** | **1,276,745.42** |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 1,029,982.50 | 1,244,854.37 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 36,711.42 | 30,652.62 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **221,298.63** | **213,160.18** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **4,678,506.32** | **2,356.30** |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | 4,369,243.93 | 0.00 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 309,262.39 | 0.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-4,457,207.69** | **210,803.88** |

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/мянган төгрөг/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,856,356.15** | **4,054,460.44** | **834,077.72** | **6,744,894.31** |
| **10** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **547,324.88** | **92,272.28** | **1,351,270.82** | **1,990,867.99** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **547,324.88** | **92,272.28** | **5,808,478.52** | **6,448,075.68** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **-1,309,031.27** | **-3,962,188.15** | **4,974,400.79** | **-296,818.63** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **-4,457,207.69** | **-4,457,207.69** |
| **11** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **547,324.88** | **92,272.28** | **1,351,270.82** | **1,990,867.99** |
| **20** | **2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **547,324.88** | **89,828.40** | **1,554,218.59** | **2,191,371.87** |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **547,324.88** | **92,272.28** | **1,343,414.71** | **1,983,011.87** |
| 12 | Нягтлан бодох бүртэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -7,856.12 | -7,856.12 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | -2,443.88 | 0.00 | -2,443.88 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | **0.00** | **0.00** | **210,803.88** | **210,803.88** |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,380,612.82** | **3,017,728.13** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **434,836.52** | **585,400.01** |
| **110** | **Орлогын албан татвар** | **209,087.48** | **238,092.39** |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | **209,087.48** | **238,092.39** |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх | 153,123.22 | 186,314.88 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 18,683.10 | 10,279.64 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 35,405.56 | 40,389.95 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны орлого | 1,875.60 | 1,107.92 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | **57,696.51** | **68,986.14** |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 1,006.11 | 2,214.87 |
| 113002 | Бууны албан татвар | 8,040.00 | 7,620.00 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | 48,650.40 | 59,151.27 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | **168,052.54** | **278,321.48** |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | **11,714.36** | **13,265.84** |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 7,783.33 | 8,768.79 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 286.00 | 637.68 |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 3,645.03 | 3,859.37 |
| **1181** | **Газрын төлбөр** | **2,311.31** | **4,413.13** |
| 118101 | Газрын төлбөр | 2,311.31 | 4,413.13 |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | 154,026.86 | 260,642.51 |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 154,026.86 | 260,642.51 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **93,304.18** | **198,379.83** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **93,304.18** | **198,379.83** |
| 120003 | Торгуулийн орлого | 19,339.50 | 15,842.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **73,964.68** | **182,537.83** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 69,216.56 | 111,247.83 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,748.12 | 71,290.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,852,472.12** | **2,233,948.30** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **41,421.40** | **32,643.59** |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 41,421.40 | 32,643.59 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **27,560.62** | **14,239.74** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 24,919.09 | 2,794.95 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,641.53 | 11,444.79 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,783,490.10** | **2,187,064.97** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,029,982.50 | 1,244,854.37 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 555,685.10 | 679,299.80 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 197,822.50 | 262,910.80 |

| | | | |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,027,009.92** | **2,511,926.48** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,027,009.92** | **2,511,926.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **918,750.25** | **1,212,540.39** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **331,210.29** | **422,254.96** |
| 210101 | Үндсэн цалин | 234,355.99 | 291,297.46 |
| 210102 | Нэмэгдэл | 37,981.57 | 100,103.80 |
| 210104 | Урамшуулал | 4,859.33 | 30,853.70 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 54,013.41 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **39,737.01** | **53,050.81** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,661.90 | 36,343.70 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,056.29 | 4,275.01 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,778.06 | 3,445.11 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 650.97 | 791.46 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,589.79 | 8,195.53 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **324,220.13** | **372,979.28** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 23,288.83 | 31,096.13 |
| 210302 | Түлш, халаалт | 299,261.30 | 340,364.64 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,670.00 | 1,518.50 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **32,592.96** | **43,591.47** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,849.96 | 8,219.34 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,236.50 | 29,916.28 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,115.60 | 3,589.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,790.90 | 1,267.70 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 600.00 | 599.15 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **23,699.10** | **20,167.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,503.10 | 378.73 |
| 210604 | Урсгал засвар | 22,196.00 | 19,788.27 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,156.00 | 18,682.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,156.00 | 18,682.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **57,955.01** | **86,316.47** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 54,433.01 | 83,520.97 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500.00 | 500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 400.00 | 359.50 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 218.00 | 218.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 240.00 | 218.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 564.00 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,300.00 | 1,500.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 300.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **101,179.75** | **195,498.41** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 96,636.95 | 191,588.41 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,542.80 | 3,910.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,108,259.67** | **1,299,386.08** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **31,535.20** | **20,649.70** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 17,966.20 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,569.00 | 20,649.70 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,076,724.47** | **1,278,736.38** |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 1,029,982.50 | 1,244,854.37 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 41,421.40 | 32,643.59 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 5,320.56 | 1,238.43 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **353,602.90** | **505,801.66** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **235,387.70** | **394,975.17** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **235,387.70** | **394,975.17** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **235,387.70** | **394,975.17** |
| 220001 | Барилга байгууламж | 197,180.00 | 354,895.94 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 38,207.70 | 40,079.23 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-235,387.70** | **-394,975.17** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **118,215.21** | **110,826.49** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 265,428.61 | 383,643.82 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 383,643.82 | 494,470.30 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/мянган төгрөг/**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувиар |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,843,209.90** | **1,545,163.95** | **298,045.95** | **83.8%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,406,225.10** | **1,260,268.01** | **145,957.09** | **89.6%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,385,571.90** | **1,239,618.31** | **145,953.59** | **89.5%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **437,704.10** | **422,254.96** | **15,449.14** | **96.5%** |
| 210101 | Үндсэн цалин | 312,048.00 | 291,297.46 | 20,750.54 | 93.4% |
| 210102 | Нэмэгдэл | 120,856.10 | 100,103.80 | 20,752.30 | 82.8% |
| 210104 | Урамшуулал | 4,800.00 | 30,853.70 | -26,053.70 | 642.8% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **56,188.20** | **53,050.81** | **3,137.39** | **94.4%** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,207.80 | 36,343.70 | 1,864.10 | 95.1% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,495.10 | 4,275.01 | 220.09 | 95.1% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,596.10 | 3,445.11 | 150.99 | 95.8% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 899.00 | 791.46 | 107.54 | 88.0% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,990.20 | 8,195.53 | 794.67 | 91.2% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **375,276.80** | **372,979.28** | **2,297.52** | **99.4%** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 32,747.40 | 31,096.13 | 1,651.27 | 95.0% |
| 210302 | Түлш, халаалт | 340,899.40 | 340,364.64 | 534.76 | 99.8% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,630.00 | 1,518.50 | 111.50 | 93.2% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **45,694.80** | **43,591.47** | **2,103.34** | **95.4%** |
| 210401 | Бичиг хэрэг | 8,543.60 | 8,219.34 | 324.26 | 96.2% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,399.80 | 29,916.28 | 1,483.53 | 95.3% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,651.40 | 3,589.00 | 62.40 | 98.3% |
| 210404 | Ном, хэвлэл | 1,500.00 | 1,267.70 | 232.30 | 84.5% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 600.00 | 599.15 | 0.85 | 99.9% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **50,700.00** | **49,146.80** | **1,553.20** | **96.9%** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 30,800.00 | 29,358.53 | 1,441.47 | 95.3% |
| 210604 | Урсгал засвар | 19,900.00 | 19,788.27 | 111.73 | 99.4% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 19,395.70 | 18,682.00 | 713.70 | 96.3% |
| 210702 | Дотоод албан томилолт | 19,395.70 | 18,682.00 | 713.70 | 96.3% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **87,921.40** | **84,414.59** | **3,506.81** | **96.0%** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 85,063.40 | 81,619.09 | 3,444.31 | 96.0% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500.00 | 500.00 | 0.00 | 100.0% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 400.00 | 359.50 | 40.50 | 89.9% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 218.00 | 218.00 | 0.00 | 100.0% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 240.00 | 218.00 | 22.00 | 90.8% |
| 210807 | Газрын төлбөр | 1,500.00 | 1,500.00 | 0.00 | 100.0% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **312,690.90** | **195,498.41** | **117,192.49** | **62.5%** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 305,690.90 | 191,588.41 | 114,102.49 | 62.7% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,000.00 | 3,910.00 | 3,090.00 | 55.9% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **20,653.20** | **20,649.70** | **3.50** | **100.0%** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **20,653.20** | **20,649.70** | **3.50** | **100.0%** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 20,653.20 | 20,649.70 | 3.50 | 100.0% |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **436,984.80** | **284,895.94** | **152,088.86** | **65.2%** |
| 220001 | Барилга байгууламж | 436,984.80 | 284,895.94 | 152,088.86 | 65.2% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,843,209.90** | **1,587,659.40** | **255,550.50** | **86.1%** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **269,818.20** | **0.00** | **269,818.20** | **0.0%** |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 269,818.20 | 0.00 | 269,818.20 | 0.0% |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,248,687.00** | **1,475,121.58** | **-226,434.58** | **118.1%** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,248,687.00 | 1,212,210.78 | 36,476.22 | 97.1% |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 0.00 | 262,910.80 | -262,910.80 | 0.0% |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **324,704.70** | **112,537.83** | **212,166.88** | **34.7%** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 150,347.40 | 111,247.83 | 39,099.58 | 74.0% |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000.00 | 1,290.00 | -290.00 | 129.0% |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 173,357.30 | 0.00 | 173,357.30 | 0.0% |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 173,357.37 | -173,357.37 | 0.0% |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 215,852.82 | -215,852.82 | 0.0% |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **48** | **48** | 0.00 | 100.0% |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **2** | **2** | 0.00 | 100.0% |
| 610001 | Төсвийн байгууллага | 2 | 2 | 0.00 | 100.0% |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **23** | **23** | 0.00 | 100.0% |
| 620001 | Удирдах ажилтан | 9 | 9 | 0.00 | 100.0% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 12 | 12 | 0.00 | 100.0% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2 | 2 | 0.00 | 100.0% |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **23** | **23** | 0.00 | 100.0% |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 10 | 10 | 0.00 | 100.0% |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 6 | 6 | 0.00 | 100.0% |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 7 | 7 | 0.00 | 100.0% |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/мянган төгрөг/**

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **27,560.60** | **14,239.70** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **27,560.60** | **14,239.70** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **22,240.00** | **13,001.30** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **22,240.00** | **13,001.30** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 22,240.00 | 13,001.30 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **5,320.60** | **1,238.40** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **5,320.60** | **1,238.40** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 5,320.60 | 1,238.40 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **27,560.60** | **14,239.70** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 24,919.10 | 2,794.90 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,641.50 | 11,444.80 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жаргалант сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төр, иргэнээ дээдэлсэн өрх гэр, хүний хөгжилийг дэмжсэн төрийн захиргааны мэргэшсэн хамт олон байж ногоон эдийн засагт суурилсан манлайлагч сум болно” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйг хөгжүүлэх
- Газар тариаланг хөгжүүлэх
- Нийтийн аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Байгаль хамгаалах хөтөлбөр
- Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх
- Төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, сургалт сурталчилгаа
- Сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх
- Монгол улсын Засгийн газраас Боловсрол Соёл, Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- Иргэдийн оролцоог хангах

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ татан авах тухай хууль/г.м/

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор

дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2018 онд аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

## 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 157,510.7 мянган төгрөгөөр буюу 2 хувиар *буурсан* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/*

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | | Эцсийн үлдэгдэл | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| Б | Дүн | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь |
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **671,612.44** | **33.7%** | **832,204.80** | **37.9%** | **160,592.36** | **77.9%** |
| Мөнгөн хөрөнгө | 383,643.82 | 19.3% | 494,470.30 | 22.5% | 110,826.48 | 53.8% |
| Авлага | 158,534.70 | 8.0% | 185,229.70 | 8.4% | 26,695.00 | 13.0% |
| Урьдчилгаа | | 0.0% | | 0.0% | 0.00 | 0.0% |
| Бараа материал | 129,433.92 | 6.5% | 152,504.80 | 6.9% | 23,070.88 | 11.2% |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,319,318.78** | **66.3%** | **1,364,780.06** | **62.1%** | **45,461.28** | **22.1%** |
| Үндсэн хөрөнгө | 2,181,450.90 | 109.6% | 2,334,690.28 | 106.3% | 153,239.38 | 74.4% |
| Хуримтлагдсан элэгдэл | -862,132.12 | -43.3% | -969,910.22 | -44.1% | -107,778.10 | -52.3% |
| **Нийт хөрөнгө** | **1,990,931.22** | **100.0%** | **2,196,984.86** | **100.0%** | **206,053.64** | **100.0%** |
| Өр төлбөр | 63.24 | 0.0% | 5,612.99 | 0.26% | 5,549.75 | 2.7% |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,898,595.70 | 95.4% | 2,101,543.47 | 95.66% | 202,947.77 | 98.5% |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 92,272.28 | 4.6% | 89,828.40 | 4.09% | -2,443.88 | -1.2% |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмч** | **1,990,931.22** | **100.0%** | **2,196,984.86** | **100.00%** | **206,053.64** | **100.0%** |

*Эх сурвалж: Жаргалант сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 383,643.82 мянга, эцсийн үлдэгдэл 494,470.3 мянган төгрөг болж 110,826.48 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|---|
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ ДҮН** | **383,643.82** | **494,470.3** | **110,826.48** |
| **31200** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **383,643.82** | **494,470.3** | **110,826.48** |
| **31210** | **Төгрөг** | **383,643.82** | **494,470.3** | **110,826.48** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 383,643.82 | 494,470.3 | 110,826.48 |

*Эх сурвалж: Жаргалант сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 494,470.3 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 148,600.0 мянга, Хоршоо хөгжүүлэх сангийн дансанд 67,252.9 мянга, орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 278,617.5 мянган төгрөг байршиж байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 219,689.8 мянга, эцсийн үлдэгдэл 135,648.8 мянган төгрөг болж 84,041.0 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (- | Хувь |
|---|---|---|---|---|
| Ажиллагсадтай холбогдсон авлага | 3,500.00 | 3,516.00 | 16.00 | 1.9% |
| Татаас санхүүжилтын авлага | | | 0.00 | 0.0% |
| Байгууллагаас авах авлага | 5,320.60 | | -5,320.60 | 0.0% |
| Хувь хүмүүсээс авах авлага | | | 0.00 | 0.0% |
| Хувь хүмүүст олгосон зээл | 149,714.10 | 181,713.70 | 31,999.60 | 98.1% |
| Хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээл | | | 0.00 | 0.0% |
| **Дүн** | **158,534.70** | **185,229.70** | **26,695.00** | **100.0%** |

*Эх сурвалж: Жаргалант сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Тайлант онд авлага дансны үлдэгдэл өссөн шалтгаан нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл /байгууллагаар/ /мянган төгрөгөөр/*

| Д.д | Байгууллагуудын нэр | Авлагын эхний үлдэгдэл | Авлагын эцсийн үлдэгдэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 3,500.0 | 3,500.0 | - | 1.9% |
| 2 | Засаг даргын тамгын газар | 5,320.6 | 16.0 | -5,304.6 | 0% |
| 3 | Орон нутгийн хөгжлийн сан | | | | |
| 4 | Хоршоо хөгжүүлэх сан | 149,714.1 | 181,713.7 | 31,999.6 | 98.1% |
| | **НИЙТ ДҮН** | **158,534.7** | **185,229.7** | **26,695.0** | **100.0%** |

*Эх сурвалж: Жаргалант сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Нийт авлагын 98.1 хувь буюу 181,713.7 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн авлага, 1.9 хувь буюу 3,500.0 мянган төгрөг нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажиллагсадтай холбоотой авлага байна. Хоршоо хөгжүүлэх сангийн авлага оны эхэнд 149,714.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тус онд 105,000.0 мянган төгрөгийн зээл олгож 73,000.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулж оны эцэст 181,713.7 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 129,433.9 мянга, эцсийн үлдэгдэл

152,504.8 төгрөг болж 23,070.9 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл* */ мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|
| Бичиг хэргийн материал | 1,720.60 | 2,865.50 | 1,144.90 | 1.9% |
| Аж ахуйн материал | 19,981.90 | 46,115.70 | 26,133.80 | 30.2% |
| Барилгын засварын материал | 390.80 | 390.80 | 0.00 | 0.3% |
| Бусад хангамжийн материал | 60,952.10 | 56,946.50 | -4,005.60 | 37.3% |
| Мал амьтад | 31,388.50 | 46,186.30 | 14,797.80 | 30.3% |
| Нөөцийн бараа | 15,000.00 | | -15,000.00 | 0.0% |
| **Дүн** | **129,433.90** | **152,504.80** | **23,070.90** | **100.0%** |

*Эх сурвалж: Жаргалант сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Бараа материалын дансны үлдэгдэл 152,504.8 мянган төгрөг болж өмнөх оноос 23,070.9 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, мал амьтад дансны үлдэгдэл нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

*Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл* */мянган төгрөгөөр/*

| Бараа материалын орлого, зарлагын үзүүлэлт | Дүн |
|---|---|
| **2023 оны эхний үлдэгдэл** | **129,433.9** |
| ***Нэмэгдсэн*** | **227,516.0** |
| Худалдан авсан | 146,607.2 |
| Шилжүүлэн авсан | 7,797.8 |
| Бусад | 73,111.0 |
| ***Хасагдсан*** | **204,445.1** |
| Худалдсан, зарцуулсан | 189,445.1 |
| Шилжүүлсэн | 15,000.0 |
| **2023 оны эцсийн үлдэгдэл** | **152,504.8** |

*Эх сурвалж: Жаргалант сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Тайлант онд нийт нэмэгдсэн 227,516.0 мянган төгрөгийн бараа материалын 146,607.2 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч ОНХС-ын хөрөнгөөр худалдан авсан өвс, тэжээл 50,168.0 сая төгрөг, мал амьтад 7,797.8 сая төгрөг, камержуулалтын дагалдах хэрэгсэл 15,943.0 сая, үнэ төлбөргүй мал амьтад 7,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Мөн тайлант онд нийт 189,445.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, ЗДТГ-ын нөөцөд бүртгэлтэй байсан 15,000.0 мянган төгрөгийн бараа материалыг Жаргалант сумын Ерөнхий Боловсролын Сургууль руу шилжүүлсэн, байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,334,690.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 153,239.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

*Эх сурвалж: Жаргалант сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|
| **БИЕТ ХӨРӨНГӨ** | **2,078,438.90** | **2,231,678.30** | **153,239.40** | **95.3%** |
| Барилга байгууламж, орон сууц | 808,498.60 | 899,994.00 | 91,495.40 | 37.1% |
| Тээврийн хэрэгсэл | 226,610.80 | 199,800.80 | -26,810.00 | 10.4% |
| Машин тоног төхөөрөмж | 272,597.90 | 312,266.70 | 39,668.80 | 12.5% |
| Тавилга эд хогшил | 124,365.50 | 109,438.90 | -14,926.60 | 5.7% |
| Зам гүүрийн байгууламж | 194,620.00 | 214,620.00 | 20,000.00 | 8.9% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дуусаагүй барилга байгууламж | | | 0.00 | 0.0% |
| Номын фонд | | | 0.00 | 0.0% |
| Бусад үндсэн хөрөнгө | 451,746.10 | 495,557.90 | 43,811.80 | 20.7% |
| **БИЕТ БУС ХӨРӨНГӨ** | **103,012.00** | **103,012.00** | **0.00** | **4.7%** |
| Программ хангамж | 200.00 | 200.00 | 0.00 | 0.0% |
| Бусад биет бус хөрөнгө | 102,812.00 | 102,812.00 | 0.00 | 4.7% |
| **НИЙТ ДҮН** | **2,181,450.90** | **2,334,690.30** | **153,239.40** | **100%** |

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,334,690.3 мянган төгрөг болж 153,239.4 мянган төгрөгөөр өссөн нь барилга байгууламж, зам гүүрийн байгууламж , машин тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийн дансны дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/*

| Байгууллагуудын нэрс | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 17,207.8 | 24,902.9 | 7,695.1 | 10.7% |
| Засаг даргын тамгын газар | 2,164,243.1 | 2,309,787.4 | 145,544.3 | 89.3% |
| **Дүн** | **2,181,450.9** | **2,334,690.3** | **153,239.4** | **100%** |

*Эх сурвалж: Жаргалант сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Тайлант онд нэмэгдсэн 217,966.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нь төсвийн хөрөнгөөр 40,079.2 мянга, сумын ОНХСангийн эх үүсвэрээр 80,000.0 мянга, УТХО-аар 2,790.0 мянга, 95,096.8 мянга 64,726.7 мянган төгрөгийн барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил акталсан байна.

*Хүснэгт 9. Үндсэн хөрөнгө /мянган төгрөгөөр/*

| | |
|---|---|
| **2023 оны эхний үлдэгдэл** | **2,181,450.9** |
| ***Нэмэгдсэн*** | **217,966.0** |
| Худалдан авсан | 40,079.2 |
| Шилжүүлэн авсан | 175,096.8 |
| Бусад | 2,790.0 |
| ***Хасагдсан*** | **64,726.7** |
| Акталсан | 64,726.7 |
| Шилжүүлсэн | 0 |
| **2023 оны эцсийн үлдэгдэл** | **2,334,690.3** |

*Эх сурвалж: Жаргалант сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

### 3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 63.2 мянга, эцсийн үлдэгдэл 5,613.0 мянган төгрөг болж 5,549.8 мянган төгрөгөөр өссөн байна.

. *Хүснэгт 10. Өр төлбөр*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|
| Ажилчидтай холбоотой өглөг | 63.20 | 113.00 | 49.80 | 2.0% |
| Байгууллагад төлөх өглөг | | 5,500.00 | 5,500.00 | 98.0% |
| **Дүн** | **63.20** | **5,613.00** | **5,549.80** | **100.0%** |

Тайлант онд өр төлбөр дансны үлдэгдэл өссөн шалтгаан нь Орон нутгийн хөгжлийн сангийн өр төлбөрийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 11. Өр төлбөрийн үлдэгдэл /байгууллагаар/ /мянган төгрөгөөр/*

| Д.д | Байгууллагуудын нэр | Өр төлбөрийн эхний үлдэгдэл | Өр төлбөрийн эцсийн үлдэгдэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Иргэдийн төлөөлөгчдийн хурал | | 12.0 | 12 | 0.2% |
| 2 | Засаг даргын тамгын газар | 63.2 | 101.0 | 37.8 | 1.8% |
| 3 | Орон нутгийн хөгжлийн сан | | 5,500.0 | 5,500.0 | 98.0% |
| 4 | Хоршоо хөгжүүлэх сан | | | | |
| | **НИЙТ ДҮН** | **63.2** | **5,613.0** | **5,549.8** | **100.0%** |

Нийт өр төлбөрийн 98.0 хувь буюу 5,500.0 мянган төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн өр төлбөр, 1.8 хувь буюу 101.0 мянган төгрөг нь ЗДТГазрын ажиллагсадтай холбоотой өр төлбөр, 0.2 хувь буюу 12.0 мянган төгрөг нт ИТХ-ын ажиллагсадтай холбоотой өр төлбөр байна.

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,361,526.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,045,665.4 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 12. Засгийн газрын хувь оролцоо* */мянган төгрөгөөр/*

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,990,868.0 | 2,191,371.9 | 200,503.9 |
| Өмч: - орон нутгийн | 547,324.9 | 547,324.9 | - |
| **Хуримтлагдсан үр дүн** | 1,351,270.8 | 1,554,218.6 | 202,947.8 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 92,272.3 | 89,828.4 | -2,443.9 |
| | **1,990,931.2** | **2,196,984.9** | **206,053.7** |

*Эх сурвалж: Жаргалант сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл үлдэгдэл 2,191,371.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 200,503.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр 202,947.8 мянган төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 2,443.9 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

### 3.5.11 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2022.12.19-ний өдрийн хуралдааны 9/26 дүгээр тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 310,975.0 мянга, татварын бус орлогыг 10,000.0 мянга, ОНХС-ийн шилжүүлгийг 220,311.8 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 41,000.0 мянга, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 580,263.9 мянга, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн орлогыг 110,347.4 мянга, урд оны үлдэгдлийг 326,545.5 мянга нийт 1,599,443.6 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2023.07.07-ны өдрийн 13/15 дугаар тодотгосон тогтоолоор татварын орлогыг 349,100.8 мянга, татварын бус орлогыг 10,000.0 мянга, ОНХС-ийн шилжүүлгийг 269,818.2 мянга, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 679,299.8 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 41,000.0 мянга, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн орлогыг 110,347.4 мянга, урд оны үлдэгдлийг 383,643.7 мянга нийт 1,843,209.8 мянган төгрөгөөр баталсан байна.

*Хүснэгт 13. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл* */мянган төгрөгөөр/*

| Д/д | Орлогын нэр төрөл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **Нийт дүн** | | **359,100.80** | **601,242.24** | **242,141.44** | **167.4%** |
| **Сумд төвлөрөх орлогын дүн** | | **349,100.80** | **585,400.04** | **236,299.24** | **167.7%** |
| 1 | ИОТХ | 15,000.00 | 10,279.64 | (4,720.36) | 68.5% |
| 2 | хадгаламжийн хүүгийн орлого | 38,100.00 | 40,389.95 | 2,289.95 | 106.0% |
| 3 | ҮХЭХ борлуулсны албан татвар | 4,000.00 | 1,107.92 | (2,892.08) | 27.7% |
| 4 | Бууны татвар | 6,675.00 | 7,620.00 | 945.00 | 114.2% |
| 5 | Улсын тэмдэгт | 6,700.00 | 8,768.79 | 2,068.79 | 130.9% |
| 6 | Газрын төлбөр | 2,700.00 | 4,413.13 | 1,713.13 | 163.4% |
| 7 | Ан агнуур | 36,000.00 | 260,642.51 | 224,642.51 | 724.0% |
| 8 | Газрын дуудлага худалдаа | 1,200.00 | - | (1,200.00) | 0.0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | Хог хаягдлын үйлчилгээний төлбөр | 6,600.00 | 3,859.37 | (2,740.63) | 58.5% |
| 10 | ЦХАТ /суутган/ | 166,980.00 | 186,314.88 | 19,334.88 | 111.6% |
| 11 | ҮХЭХ-ийн татвар | 1,700.00 | 2,214.87 | 514.87 | 130.3% |
| 12 | Малын тоо толгойн албан татвар | 62,945.80 | 59,151.27 | (3,794.53) | 94.0% |
| 13 | ТТАМАТөлбөр | 500.00 | 637.70 | 137.70 | 127.5% |
| **Татварын бус орлого** | | **10,000.00** | **15,842.20** | **5,842.20** | **158.4%** |
| 14 | Хүү торгууль | 10,000.00 | 15,842.20 | 5,842.20 | 158.4% |

*Эх сурвалж: Жаргалант сумын ИТХ-ын тогтоол*

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 242,141.4 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн ч орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлогын татвар хураамж 4,720.4 мянга, ҮХЭХ борлуулсны албан татвар 2,892.1 мянга, газрын дуудлага худалдаа 1,200.0 мянга, хог хаягдлын хураамж 2,740.6 мянга, ҮХЭХ-ийн татвар 297.3 мянга, малын тоо толгойн албан татвар 3,794.5 мянган төгрөгөөр тус тус батласан төлөвлөгөө биелээгүй бөгөөд нийт 5 нэр төрлийн татварын орлогын 15,347.6 мянган төгрөгөөр тасарсан байна.

### 3.5.12 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,843,209.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,545,163.9 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулсан. 1,260,268.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 284,895.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 6 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 9/26 дугээр тогтоолоор анх 1,599,443.6 мянган төгрөгөөр баталсан байна.

*Хүснэгт 14. Төсвийн төлөвлөлт* */мянган төгрөгөөр/*

| Байгууллагын нэр | Төсвийн төсөл | Анх батлагдсан төсөв | Зөрүү |
|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 142,558.0 | 121,945.3 | -20,612.7 |
| Засаг даргын Тамгын газар | 551,227.1 | 615,669.6 | 64,442.5 |
| Жаргалант сумын сургууль | 145,514.0 | 127,805.0 | -17,709.0 |
| Жаргалант сумын цэцэрлэг | 45,775.6 | 40,836.9 | -4,938.7 |
| Эрүүл мэндийн төв | 48,500.0 | 48,264.4 | -235.6 |
| Соёлын төв | 90,356.0 | 87,296.7 | -3,059.3 |
| СХСан | | 355,311.8 | |
| ОНХСан | | 202,313.9 | |
| Нийт дүн | **1,023,930.7** | **1,599,443.6** | **575,512.9** |

*Эх сурвалж: Жаргалант сумын ИТХ-ын тогтоол*

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд 2022 оны 9/26 дүгээр тогтоолоор анх 1,599,443.6 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны 13/15 тоот тогтоолоор 243,766.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,843,209.9 мянган төгрөг болсон.

Нийт эх үүсвэрийн 269,818.2 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 889,586.2 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 359,100.8 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 151,347.4 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 173,357.3 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгаас авсан санхүүгийн дэмжлэг 679,299.8 мянга, орон нутгийн орлогоос 601,242.2 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс 262,910.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 111,247.8 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 1,290.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 32,643.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 15. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* */мянган төгрөгөөр/*

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | Төвлөрүүлэлт |
|---|---|---|---|---|---|
| ЗДТГ | 734,733.40 | 720,860.50 | 13,872.90 | 98.1% | 13,872.90 |
| ИТХ | 146,604.80 | 130,115.00 | 16,489.80 | 88.8% | 16,489.80 |
| Соёлын төв | 87,296.70 | 86,654.80 | 641.90 | 99.3% | 641.90 |
| Хоршоо хөгжүүлэх сан | 219,483.90 | 105,918.50 | 113,565.40 | 48.3% | |
| Сургууль | 130,655.00 | 130,269.50 | 385.50 | 99.7% | 385.50 |
| Цэцэрлэг | 39,986.90 | 39,931.30 | 55.60 | 99.9% | 55.60 |
| ЭМТ | 47,464.40 | 46,518.40 | 946.00 | 98.0% | 946.00 |
| ОНХС | 436,984.40 | 284,895.90 | 152,088.50 | 65.2% | |
| Нийт дүн | **1,843,209.50** | **1,545,163.90** | **298,045.60** | **83.8%** | **32,391.70** |

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 86.1 хувьтай байгаа нь ЗДТГ-ын урсгал зардлыг 13,872.9 мянга, ИТХ-ын урсгал зардлыг 16,489.8 мянга, Соёлын төвийн байр ашиглалтын зардлыг 641.9 мянга, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголтыг 113,565.4 мянган, ОНХС-ын зардлыг 152,088.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### *3.5.3 Нэмэлт төсөв*

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 2,795.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоор 11,444.8 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бараа үйлчилгээний зардалд 13,001.3 мянган төгрөгийг зарцуулж, 1,238.4 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 15. Нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | ЗДТГ | ИТХ | Нийт |
|---|---|---|---|
| **Нийт нэмэлт санхүүжилтийн орлого** | | | |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,495.0 | 1,300.0 | 2,795.0 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,444.8 | 0 | 11,444.8 |
| **НИЙТ ЗАРЛАГА** | **12,939.8** | **1,300.0** | **14,239.8** |
| Бараа, ажил үйлчилгээний зардал | 11,701.3 | 1,300.0 | 13,001.3 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | - | - |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | - | - |
| **ТӨВЛӨРҮҮЛСЭН** | **13,001.3** | **-** | **13,001.3** |

*Эх сурвалж: Жаргалант сумын санхүүгийн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан*

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сумын засаг даргын нөөц санг 58,207.0 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 57,932.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус байгууллагын 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 5 бүлэг, 6 зорилго, 85 зорилттойгоор төлөвлөж, дэвшүүлсэн зорилтын хүрээнд хэрэгжилтийг 91.4 хувийн гүйцэтгэлтэй үнэлжээ.

### 3.5.5 Аудитын гол асуудал

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 1,843,209.9 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,545,163.9 мянган төгрөгийг зарцуулж, 86.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тус сум нь 14 нэр төрлийн орлогоор 359,100.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 601,242.1 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 167.4 хувьтай биелүүлсэн.

Сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Жаргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Жаргалант сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

*Хүснэгт №16. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн*

| Байгууллагын нэр | Байгууллагын тоо | | | | Аудитын санал дүгнэлтийн төрөл | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Гүйцэтгэсэн | | | Үүнээс | | | |
| | Хамрагдвал зохих | Хамрагдсан | Бие даах дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Бүгд | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| **ЗДТГ** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **ИТХурал** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **ОНХС** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **СХС** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **НИЙТ ДҮН** | **4** | **4** | | **4** | | | | | |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

Сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Нийт илэрсэн зөрчлөөс санхүүгийн тайлангийн 22,583.2 мянган төгрөгийн 4 зөрчил илэрчээ. Хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн*

| Байгууллагын нэр | Нийт алдаа зөрчлийн дүн | | Залруулга | | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тогтоосон төлбөрийн акт | | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Санхүүгийн тайлангийн зөрчил** | | | | | | | | | | |
| **ЗДТГ** | 2 | 15,292.7 | 1 | 13,872.7 | 1 | 1,420.0 | | | | |
| **ИТХ** | 2 | 7,290.5 | | | 1 | 235.0 | 1 | 7,055.5 | | |
| ***СТА зөрчлийн дүн*** | ***4*** | ***22,583.2*** | ***1*** | ***13,872.7*** | ***2*** | ***1,655.0*** | ***1*** | ***7,055.5*** | | |
| **СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал** | | | | | | | | | | |
| ***Нийцлийн аудитын дүн*** | | | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | | | |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчлийг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал:

*Хүснэгт 18: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт*

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **Харьяа төсвийн байгууллагуудын дүн** | | **7,290.5** | | | |
| **Засаг даргын тамгын газар** | | **0** | | | |
| **Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** | | | | | |
| 1 | | | | | |
| **ИТХ** | | **7,290.5** | | | |
| **Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** | | | | | |
| Төсвийн хөрөнгийг бэлэг дурсгалын зүйл худалдан авахад зарцуулсан | | 235.0 | Төлбөрийн акт | Дарга, нягтлан бодогч | Д.Уранчимэг Д.Баттөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| Жилийн эцсийн бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, эд хөрөнгийн тооллогын дүнг баталгаажуулаагүй. | | 7,055.5 | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | Д.Уранчимэг Д.Баттөр |
| Дүн | | **7,290.5** | | | |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

### 3.5.6 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 1,843,209.9 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 1,545,163.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

*Хүснэгт 15. Төсвийн гүйцэтгэлийн тайлан* */мянган төгрөгөөр/*

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | **70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага** | **734,733.40** | **720,860.40** | **13,873.00** | **98.1%** |
| | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 491,767.60 | 483,882.50 | 7,885.10 | 98.4% |
| | 80106 Баг, хорооны ҮАЗардал | 86,265.40 | 83,607.80 | 2,657.60 | 96.9% |
| | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 14,880.00 | 14,880.00 | 0.00 | 100.0% |
| | 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 58,207.00 | 57,932.60 | 274.40 | 99.5% |
| | 81701 Байгаль орчныг хамгаалах, нөхө | 77,013.40 | 77,013.40 | 0.00 | 100.0% |
| | 82212 Хур хог хаягдал, орчны бохирдл | 6,600.00 | 3,544.10 | 3,055.90 | 53.7% |
| 2 | **70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага** | **146,604.80** | **130,115.00** | **16,489.80** | **88.8%** |
| | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 142,604.80 | 126,118.30 | 16,486.50 | 88.4% |
| | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 4,000.00 | 3,996.70 | 3.30 | 99.9% |
| 3 | **Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт** | **436,984.80** | **284,895.80** | **152,089.00** | **65.2%** |
| | 80904 Нийгмийн зориулалттай барилга | 104,220.80 | 20,907.20 | 83,313.60 | 20.1% |
| | 83401 ОНХС - Иргэлцүүрээр олгох | 263,088.20 | 256,180.80 | 6,907.40 | 97.4% |
| | 83403 ОНХС - Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр | 6,730.00 | 6,730.00 | 0.00 | 100.0% |
| | 83405 ОНХС - Малын тоо толгойн албан татвар | 62,945.80 | 1,077.80 | 61,868.00 | 1.7% |
| 4 | **72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих** | **219,483.90** | **105,918.50** | **113,565.40** | **48.3%** |
| | 82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих | 219,483.90 | 105,918.50 | 113,565.40 | 48.3% |
| 5 | **71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | **47,464.40** | **46,518.40** | **946.00** | **98.0%** |
| | 80112 Нийтлэг үйлчилгээ | 47,464.40 | 46,518.40 | 946.00 | 98.0% |
| 6 | **71802 Ерөнхий боловсрол** | **130,655.00** | **130,269.40** | **385.60** | **99.7%** |
| | 80112 Нийтлэг үйлчилгээ | 130,655.00 | 130,269.40 | 385.60 | 99.7% |
| 7 | **71801 Сургуулийн өмнөх боловсрол** | **39,986.90** | **39,931.20** | **55.70** | **99.9%** |
| | 80112 Нийтлэг үйлчилгээ | 39,986.90 | 39,931.20 | 55.70 | 99.9% |
| 8 | **71702 Соёл урлаг** | **87,296.70** | **86,654.80** | **641.90** | **99.3%** |
| | 80112 Нийтлэг үйлчилгээ | 87,296.70 | 86,654.80 | 641.90 | 99.3% |
| | **Нийт** | **1,843,209.90** | **1,545,163.50** | **298,046.40** | **83.8%** |

*Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан*

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар

сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Жаргалант аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 23-ний өдрийн 1/44 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,289,898.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 12.899.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 9,029.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Жаргалант сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,655.0 төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосон. Тогтмол зардлын батлагдсан төлөвлөгөөг 98%-ийн гүйцэтгэлтэйгээр зарцуулж 8,014.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### 4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

## 4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.7.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгээгүй болно.

### 4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/141 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 16. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж* */ мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 100 |
| ***Нийт*** | ***1*** | **0** | ***1*** | **0** | **0** | **0** | **100** |

*Эх сурвалж: Шийдвэрийн хэрэгжилт*

## 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,638.2 мянган төгрөгийн 2 зөрчил[1] илэрсэнд алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

## 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u>* Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 242,141.4 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн ч орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлогын татвар хураамж 4,720.4 мянга, ҮХЭХ борлуулсны албан татвар 2,892.1 мянга, газрын дуудлага худалдаа 1,200.0 мянга, хог хаягдлын хураамж 2,740.6 мянга, ҮХЭХ-ийн татвар 297.3 мянга, малын тоо толгойн албан татвар 3,794.5

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мянган төгрөгөөр тус тус батласан төлөвлөгөө биелээгүй бөгөөд нийт 5 нэр төрлийн татварын орлогын 15,347.6 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8[2], Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3[3] дахь заалт, мөн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөж, зарцуулах зөвлөмжийг хүргүүлэв.

2. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Жаргалант сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7,290.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 235.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7,055.5 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14.2.10[4] дахь заалтыг зөрчсөн бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Харьяа төсөвт байгууллагуудын санхүү төсвийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх, төсвийн сахилга батыг дээшлүүлж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Жаргалант сумын Засаг дарга | 2 | 22,368.5 | | | | | 2 | 22,368.5 | | | | |
| **Дүн** | 2 | 22,368.5 | | | | | 2 | 22,368.5 | | | | |

[2] Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ
[3] жинхэнэ хэрэгжилтийн
[4] өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.